

2000 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

*Ш.Догмийчойдон**
*О.Мөнхбаяр***

- 01.13 Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабандид ОХУ-ын Элчин сайд Олег Михайлович Дерковский итгэмжлэх жуух бичгээ барив.
- 01.20 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Норвегийн Вант Улсын Элчин сайд Хакон Бардсон Хелдег итгэмжлэх жуух бичгээ барив.
- 01.22-24 Дэд Бүтцийн хөгжлийн Сайд Г.Батхүү тэргүүтэй Монгол Улсын Засгийн Газрын төлөөлөгчид Эрхүү мужид айлчлав. Айлчлалын үеэр “Монгол Улсын Засгийн Газрын байгууллагууд, ОХУ-ын Эрхүү мужийн хооронд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын талаар хамтран ажиллах тухай” Хэлэлцээр болон айлчлалын дүнгийн тухай Протоколд тус тус гарын үсэг зурав.
- 01-р сард “Иргэд харилцан зорчих журмын тухай” Монгол Улсын Засгийн Газар, БНСВУ-ын Засгийн Газрын хоорондын хэлэлцээрт Монгол Улсаас БНСВУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд А.Цолмон, БНСВУ-ын ГЯЯ-ны сайд Чу Гуан Кан нар Ханой хотноо гарын үсэг зурав. Энэхүү хэлэлцээр нь хоёр орны иргэдийг аль болох чөлөөтэй зорчуулах таатай нөхцөл бүрдүүлэх зорилго агуулжээ.
- 01-р сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 54-р чуулганд Монгол Улсын Ерөнхий сайд Р.Амаржаргал тэргүүтэй төлөөлөгчид оролцож, ерөнхий шүүмжлэлд болон чуулганаар хэлэлцсэн тодорхой асуудлаар Засгийн Газрын байр суурийг илэрхийлж нийтдээ 35 удаа үг хэлэв. Чуулганы үеэр манай улсыг НҮБ-

* Ш.Догмийчойдон - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

** О.Мөнхбаяр - МУИС-ийн ОУХС-ийн оюутан

- ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах эрх зүйн үндэс болох санамж бичиг болон манай Засгийн Газар, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн хоорондын хамтын ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон ойлголцлын санамж бичигт тус тус гарын үсэг зурав.
- 02.03-06 Монгол Улсын ГХ-ны сайд Н.Туяа Норвегийн Вант Улсад албан ёсоор айлчлав.
- 02.08-09 Монгол Улсын гадаад харилцааны сайд Н.Туяа Швед Улсад албан ёсоор айлчлав. Сайд Н.Туяа Швед Улсын ГХ-ны сайд хатагтай Анна Линдтай хэлэлцээ хийв.
- 02.09-12 ХБНГУ-ын Холбооны Засгийн газрын Азийн бодлогын асуудлыг эрхлэгч, Элчин сайд ноён К.Зоммэр манай улсад ажлын айлчлал хийв. Тэрээр Монгол Улсын Ерөнхий сайд Р.Амаржаргалд бараалхаж Монгол-Германы харилцаа болон харилцан сонирхсон бусад асуудлаар ярилцаж санал солилцов.
- 02.10-11 Монгол Улсын ГХ-ны сайд Н.Туяа БНФинлянд Улсад албан ёсоор айлчлав. Сайд Н.Туяа БНФинлянд Улсын Ерөнхийлөгч Марти Ахтисаарид бараалхаж, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Юкка Валтасааритай хэлэлцээ хийв. Монгол-Финляндын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт ГХ-ны сайд Н.Туяа, Финляндын Тээвэр, холбооны сайд Олли-Пека Хейнонен нар гарын үсэг зурав.
- 02.12-16 БНКУ-ын Төрийн Зөвлөлийн болон Засгийн газрын дарга Ф.Кастрогийн бие төлөөлөгч БНКУ-ын ГХЯ-ны харьяа Олон улсын Хэвлэлийн төвийн дэд дарга Альберто Веласко Гавана хотноо 2000.04.10-14-нд болох Өмнөдийн орнуудын Дээд хэмжээний уулзалтад оролцохыг урьсан урилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандил гардуулахаар Улаанбаатарт ирж ажиллав.
- 02.15 Тайландын Вант Улсад Монгол Улсын ЭСЯ-ыг нээх ёслол Бангкок хотноо болов. Тэр үеэр Бангкок хотноо хуралдаж байсан ЮНКТАД-ын чуулганд

- 02.20-26 оролцсон ГХ-ны сайд Н.Туяа ЭСЯ-ыг нээж үг хэлэв. Монгол Улсын ГХ-ны сайд Н.Туяа АНУ-д албан ёсоор айлчлав. Сайд Н.Туяа АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайт, Конгрессийн гишүүн Жозеф Питтс, Дэлхийн Банкны бүс нутаг хариуцсан Гүйцэтгэх захирал Нийл Хайдэн, Монголыг хариуцсан захирал Н.Оконжо-Ивеала болон албаны бусад хүмүүстэй уулзав.
- 02.27-03.03 Монгол Улсын Ерөнхий сайд Р.Амаржаргал Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад албан ёсоор айлчлав. Айлчлалын үеэр агаарын харилцааны тухай Монгол, Британийн засгийн газар хоорондын хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурав.
- 02.28 “Орлого ба хөрөнгийн татварийг давхар ноогдуулахгүй байх тухай Монгол Улс, БНБУ-ын хоорондын конвенци”-д Монгол Улсаас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд Б.Алтангэрэл, Болгарын Сангийн сайд М.Радев нар Софи хотноо гарын үсэг зурав.
- 02.28-03.04 БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн урилгаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Болд тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчлав. Төлөөлөгчид айлчлах хугацаандаа БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн орлогч дарга, Төрийн Зөвлөлийн гишүүн, БХЯ-ны сайд Чи Хаотянь болон бусад албан тушаалтнуудтай уулзаж хоёр орны харилцаа хамтын ажиллагаа болон бүс нутгийн аюулгүй байдлын харилцан сонирхсон асуудлаар санал солилцов.
- 03.01-06 БНХАУ-ын ГЯЯ-ны урилгаар Монгол улсын ГХЯ-ны төлөөлөгчид Бээжинд айлчилж, хоёр орны ГХЯ-ны хооронд бүс нутаг, олон улсын асуудлаар зөвлөлдөх уулзалт хийв.
- 03.08-15 Монгол улс, ОХУ-ын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан төлөөлөгчдийн уулзалт Улаанбаатар хотноо болж хилийн шалгалтын дүнгийн бичиг баримтуудыг хэвлэх ажлын явц байдал, санхүүжилтийн талаар ярилцав.

- 03.14 Япон улсын Засгийн газраас Монгол улсын засгийн газарт 1999 оны санхүүгийн жилд 1 тэрбум 900 сая иений төслийн бус булалтгүй тусламж олгох тухай болон Монгол улсын засгийн газарт Японы засгийн газраас 1999 оны санхүүгийн жилд 40 сая иений “Хүнсний КР-1 булалтгүй тусламж” олгох тухай албан ёсны ноот бичгүүдэд ГХ-ны сайд Н.Туяа, Япон улсаас тус улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд М.Ханада ГХЯ-нд гарын үсэг зурав.
- 03.21-22 БНСловак Улсын Гадаад Хэргийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга Ярослав Хлебо манай улсад ажлын айлчлал хийв.
- 03.24 Монгол улсын хууль зүйн сайд Даш-Ганболд АНУ-д ажлын айлчлал хийв.
- 03.20-26 Улсын их хурлын дарга Р.Гончигдорж тэргүүтэй Монголын Парламентын төлөөлөгчид БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Төлөөлөгчид БХАТИХ-ын дарга Ли Пэн, Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жу Рунжи нартай уулзаж 2 орны харилшаа хамтын ажиллагааны талаар санал солилцов.
- 03.27 Монгол улсын засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын хооронд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт 2000–2002 онд хамтран ажиллах тухай хөтөлбөрт Монгол улсын Гэгээрлийн сайд А.Баттөр, БНТУ-ын соёлын сайд И.Талай нар Анкара хотноо гарын үсэг зурлаа.
- 03.26-30 Улсын их хурлын дарга Р.Гончигдорж тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид БНСУ-д албан ёсоор айлчлав. Манай парламентын төлөөлөгчид БНСУ-ын ерөнхийлөгч Ким Дэ Жунд бараалхав.
- 04.12 Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газрын хооронд соёлын салбарт 2000-2002 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд Элчин сайд Д.Бямбаа, БНАСАУ-ын Гадаадтай соёлоор харилцах хорооны орлогч дарга Хо Сен Ок нар Пхеньян хотноо гарыг үсэг зурав.
- 04.12-14 Куба улсын нийслэл Гавана хотод болсон Өмнөдийн орнуудын төр засгийн тэргүүн нарын дээд хэмжээний

анхдугаар уулзалтал хөгжиж байгаа 42 орны төр засгийн тэргүүн 13 орны төр засгийн тэргүүний орлогч, 67 орны ГХ-ны сайд нар оролцсон ба Монгол улсыг төлөөлж ГХ-ны сайд Н.Туяа оролцож үг хэлэв. Уг дээд хэмжээний уулзалтаар глобалчлал болон хөгжиж буй орнуудын хэтийн төлөвийн талаар голлон хэлэлцсэн юм.

04.15-17

Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар БНСВУ-ын ерөнхийлөгч Чан Дык Лыонг Монгол улсад албан ёсны айлчлал хийв. Энэхүү айлчлалын явцад Монгол улс, БНСВУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулав. Уул Гэрээнд хоёр орны ерөнхийлөгч нар гарын үсэг зурлаа. Түүнчлэн Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, иргэн, гэр бүл, эрүүгийн хэрэгт эрхийн туслалцаа үзүүлэх тухай гэрээг тус тус байгуулав. Монгол Вьетнамын Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын хооронд хамтын ажиллагааны Протокол байгуулав.

04.17-19

ГХ-ны сайд Н.Туяа НҮБ-д ажлын айлчлал хийв. Энэ айлчлал нь Монгол улсын ГХ-ны сайд тусгайлан НҮБ-д хийсэн анхны ажлын айлчлал байв. Сайд Н.Туяа НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн захирагч ноён М.Браун зэрэг хүмүүстэй уулзав.

04.20

Номхон Далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (ПЕКК)-ийн байнгын хорооны худалдаанаар Монголын үндэсний хороо (МОНПЕКК)-г ПЕКК-ийн гишүүнээр санал нэгтэй элсүүлэн авснаар Монгол улс нь ПЕКК-ийн 25 дахь гишүүн болов.

04.24-29

Монгол улсын ГХ-ны сайд Н.Туяа БНХАУ-ын ГХ-ны сайд Тан Жясюаний урилгаар БНХАУ-д албан ёсоор айлчлав. Сайд Н.Туяа БНХАУ-ын ГХ-ны сайд Тан Жясюантай албан ёсны хэлэлцээ хийж, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жу Рунжид бараалхав. Айлчлалаар хоёр тал Монгол-Хятадын харилцааны байдалд үнэлэлт өгч эдийн засаг,

- худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэх эрмэлзлэлтэй буйгаа нотлов.
- 05.21 Рига хотноо болсон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Захирагчдын зөвлөлийн 2000 оны ээлжит хуралдаанаар Монгол улсыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 61 дэх гишүүнээр элсүүлэв.
- 05.16-17 Монгол-АНУ-ын хоёр талын зөвлөлдөөн уулзалт Бангкок хотноо болж Ази Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын талаар санал солилцож АРФ-ын хүрээн дэх өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдээлэв.
- 05.18-19 АРФ-ын гишүүн орнуудын ахлах албан тушаалтнуудын уулзалт Бангкок хотноо болж манайхаас ГХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга О.Очиржав тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Манай тал уг БНАСАУ-ын АРФ-д гишүүнээр элсэх хүсэлтийг дэмжиж буйгаа илэрхийлэв.
- 05.22-24 Японы Гадаад хэргийн яамны нэгдүгээр орлогч сайд Т.Эсаки манай оронд айлчлав.
- 05.29–06.02 ХБНГУ-ын ерөнхийлөгч Ё.Раугийн урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Германд албан ёсоор айлчлав. Ерөнхийлөгч Н.Багабанди, Ё.Рау нар Хархорины археологийн малтмалын төслийг ивээлдээ авах тухай хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав.
- 06.02-06 Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди Бүгд Найрамдах Итали Улс, Ватикан улсад ажлын айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Багабанди Италийн Ерөнхийлөгч Карло Чиаampi, Ромын Гэгээн Хутагт II Иоанн Павел, Ватиканы Засгийн газрын тэргүүн, Төрийн нарийн бичгийн дарга А.Содано нартай уулзаж ярилцав. Италид хийсэн айлчлалын үр дүнгийн талаар хамтарсан мэдээ гаргаж, Италитай 2000-2003 онд соёлын салбарт хамтран ажиллах протокол байгуулав.
- 06.05-10 Нью-Йорк хотноо НҮБ-ийн төв байранд “Эмэгтэйчүүд 2000:21 дүгээр зуунд хүйсийн эрх тэгш байдал, хөгжил, энх тайван” сэдэвт НҮБ-ийн

- Ерөнхий Ассамблейн 23-р тусгай чуулганд ГХ-ны сайд Н.Туяа тэргүүтэй манай төлөөлөгчид оролцож үг хэлэв.
- 06.06-08 БНБУ-ын ерөнхийлөгч Петр Стояновын урилгаар Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди Болгарт албан ёсоор айлчлав. Болгарын ерөнхийлөгч П.Стояновтой ганцаарчлан уулзаж, өргөтгөсөн албан ёсны хэлэлцээ хийв. Айлчлалын үеэр хөрөнгө оруулалтыг дэмжиж хамгаалах хэлэлцээр, эрүүлийг хамгаалах, анагаах ухааны салбарт хамтран ажиллах хэлэлцээр болон 2000-2002 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Гадаад харилцааны яамд хоорондын хамтын ажиллагааны протоколд тус тус гарын үсэг зурав.
- 06.07 Япон Улсын Ерөнхий сайд К.Обучи агсантай салах ёс гүйцэтгэх ёслолын ажиллагаанд оролцохоор Токио хотноо хүрэлцэн очсон Монгол Улсын Ерөнхий сайд Р.Амаржаргалыг Японы Ерөнхий сайд Ё.Мори хүлээн авч уулзав.
- 06.26-27 Ардчилалын асуудлаар Варшав хотноо болсон Гадаад хэргийн сайд нарын уулзалтын хүрээнд “Ардчилалд тохиолдож буй аюулыг зайлуулах”, “Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад ардчилсан тогтолцоог бэхжүүлэх” тухай асуудлыг хэлэлцсэн ажлын хэсгийн хуралдаанд ГХ-ны сайд Н.Туяа оролцож санал бодлоо илэрхийлэв.
- 06.27-30 БНХАУ-ын ГХ-ны Яамны Азийн хэлтсийн дарга Жан Жюхуань тэргүүтэй төлөөлөгчид Монгол улсад айлчлав. Хятадын төлөөлөгчдийн ГХЯ-ны УПГ-ын дарга Бэхбат, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Очиржав нар хүлээн авч уулзлаа. Хоёр тал ОУ-ын байгууллагад гишүүнээр элсэх тухайлбал Монгол улс НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөлийн сонгуульд нэрээ дэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, БНХАУ-ыг Дэлхийн худалдааны байгууллагад элсэхэд бие биедээ дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэв.
- 06-р сард Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Перу Улсын Засгийн газар хоорондын техникийн хамтын

ажиллагааны тухай үндсэн хэлэлцээрт Монгол улсаас Перу улсад хавсран суугаа элчин сайд С.Хүрэлбаатар, Перу улсаас Монгол улсад хавсран суугаа элчин сайд В.Аритоми нар Токио хотноо гарын үсэг зурав.

07.17

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди АНУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд У.Б.Слоколсыг хүлээн авч уулзан хоёр орны цэрэг, улс төрийн харилцааны асуудлаар ярилцаж батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг энхийг сахиулах, иргэний хамгаалалт, хилийн хамгаалалтыг бэхжүүлэх чиглэлээр өргөжүүлэх боломж бийг тэмдэглэжээ.

07.26-27

Тайландын нийслэл Бангкок хотноо болсон АСЕАН-ы бүсийн чуулга (АРФ)-ын сайд нарын 7-р уулзалтанд ГХ-ны сайд Н.Туяа оролцов. Нийт 23 орныг хамарсан бүс нутгийн олон талт үйл явцад Монгол Улс 1998 онд нэгдэн орсноос хойш Сайд нарын уулзалтанд 2 дахь удаагаа оролцож байгаа юм.

08.08-10

Монгол Улсын Засгийн газрын урилгаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Хүний эрхийн дээд Комиссар хатагтай Мэри Робинсон манай оронд албан ёсны айлчлал хийв.

08.31

Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабандид Бүгд Найрамдах Унгар Улсын Элчин сайд Д-р Иштван Бало итгэмжлэх жуух бичгээ барив.

09.01-04

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Бүгд Найрамдах Филиппин Улсын Ерөнхийлөгч Жозеф Эхерсито Эстрадагийн урилгаар Филиппинд төрийн айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Багабанди Ерөнхийлөгч Эстрадагай албан ёсны хэлэлцээ хийв. Айлчлалын явцад хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, соёлын, агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны тухай Меморандум болон хоёр улсын ГХЯ хоорондын хамтын ажиллагааны талаарх баримт бичигт тус тус гарын үсэг зурав.

- 09.05-08 Монгол улсын Ерөнхийлөгч НҮБ-ын Мянганы дээд хэмжээний уулзалтад оролцон үг хэлж, төрийн тэргүүн нарын дугуй ширээний уулзалтанд оролцон тус уулзалтаас гаргасан шинэ Мянганы тунхаг хэмээх баримт бичгийг батлалцав. Ерөнхийлөгч АНУ-д байх хугацаандаа Украин, Турк, Итали, Япон, Израйль, Казахстан, Солонгос зэрэг орны төрийн тэргүүнүүдтэй уулзаж ярилцав.
- 09.08-09 Монгол Улсын Засгийн газрын урилгаар ОХУ-ын Эрхүү мужийн захирагч Б.А.Говорин тэргүүтэй төлөөлөгчид манай оронд ажлын айлчлал хийв. Б.А.Говорин Дэд бүтцийн сайд Б.Жигжид, ГХЯ-ны дэд сайд С.Батболд нартай уулзаж хоёр орны харилцаа, ялангуяа хил орчмын бүс нутгийн харилцаа амжилттай хөгжиж буйг тэмдэглэн, Монгол улс, Эрхүү мужийн хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцов.
- 09.12 АНУ-д ажлын айлчлал хийж байгаа Монгол Улсын Гадаад Харилцааны сайд Л.Эрдэнэчулуун АНУ-ын Ерөнхийлөгчийн туслах бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Азийн асуудал хариуцсан ахлах захирал К.Либертолтай уулзаж ярилцав. Тэрбээр Монгол Улсын шинэ Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулж, Монгол-Америкийн харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.
- 09.14 АНУ-ын Дээд шүүхийн шүүгч, хатагтай Сандра Дей О.Коннор манай оронд ажлын айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч нартай уулзан Монгол дахь эрх зүйн орчны талаар ярилцжээ.
- 09.19 Гадаад хэргийн дэд сайд С.Батболд Ватиканы хамбуудын Синолын Ерөнхий нарийн бичгийн дарга, эрхэмсэг гэгээнтэн хамба Ян Скоттег хүсэлтээр нь хүлээн авч уулзан Монгол Ватиканы харилцааны асуудлаар санал солилцов.
- 09.21 НҮБ-ийн төв байранд болсон далайд гаршгүй хөгжиж буй орнуудын Гадаад харилцааны сайд нарын анхны

- хуралдаанд Монгол Улсын ГХ-ны сайд Л.Эрдэнэчулуун оролцож үг хэлэв. Энэ хурлаар 13 зүйл бүхий албан мэдээ гаргажээ.
- 09.23 Ерөнхийлөгч Н.Багабандид Балбын Вант Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд Ражсшвар Ачарья Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 10.10-13 Монгол Улсын Их Хурлын даргын урилгаар БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн дарга, ЛАХН-ын Улс төрийн товчооны гишүүн Самаан Винякет тэргүүтэй төлөөлөгчид манай оронд айлчлав. Төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, УИХ-ын дарга Л.Энэбиш, УИХ дахь Монгол-Лаосын бүлгийн дарга Ц.Өөлд, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нартай уулзаж хоёр орны уламжлалт найрсаг харилцааг хөгжүүлэх талаар санал бодлоо солилцов.
- 10.16 Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайдын урилгаар манай улсад айлчилсан Италийн Аж үйлдвэр, гадаад худалдааны дэд сайд Мауро Фабрис тэргүүтэй төлөөлөгчдийг Гадаад хэргийн дэд сайд С.Батболд хүлээн авч уулзав. Уулзалтын явцад ноён М.Фабрис Итали улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүнээр 2000-2001 онд сонгогдохоор нэрээ дэвшүүлэхэд Монголын тал дэмжсэнд талархаж буйгаа илэрхийлэхийн хамт НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн Зөвлөлийн гишүүний 2002 оны сонгуульд Монгол Улсыг дэмжихээ мэдэгдэв.
- 10.17 ОХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын дарга армийн генерал Анатолий Квашнин манай оронд ажлын айлчлал хийв. Айлчлалын явцад 2001 онд Монгол Улс-ОХУ батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай төлөвлөгөөнд гарын үсэг зурав.
- 10.18 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайд Карма Толден Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 10.19 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Испани Улсын Элчин сайд Эухенио Бреголат Обиолс Итгэмжлэх жуух бичгээ барив.

- 10.28-30 МАХН-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны байнгын хорооны гишүүн, нарийн бичгийн дарга Вэй Зяньшин тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчлав. ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны байнгын хорооны гишүүн, нарийн бичгийн дарга Вэй Зяньшин МАХН-ын нарийн бичгийн дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, сайд, ЗГХЭГ-ын дарга Ө.Энхтүвшин нар хэлэлцээ хийв.
- 11.10 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Бүгд Найрамдах Финлянд Улсын Элчин сайд Тапио Калеви Саарела Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 11.13-14 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад төрийн айлчлал хийв. Айлчлалын явцад Ерөнхийлөгч нарын ганцаарчилсан уулзалт, албан ёсны хэлэлцээ болсоны сацуу В.Путин Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-ын дарга нартай уулзав. Хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол Оросын харилцааны байдалд үнэлэлт өгч, хоёр талын харилцааны цаашдын чиглэл зорилтыг тодорхойлсон “Улаанбаатарын тунхаглал”-д гарын үсэг зурав. Айлчлалын явцад Монголын орон нутгийн засаг захиргаад, ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай Хэлэлцээр, ОХУ-д буй Монгол иргэдийн булш, Монгол Улсад буй Орос цэргийн болон иргэдийн булшны статусын тухай Хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав.
- 11.17 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид АНУ-ын Элчин сайд Жон Р.Дингир Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 11.19 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар Тонгагийн Вант Улсын Цог жавхлант ван Тауфа-Ахоу-Тупоу Үү манай улсад айлчлав. Эрхэмсэг Цог жавхлант ван Тауфа-Ахоу-Тупоу Үү-ийг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди хүлээн авч хүндэтгэн зоог барьсан бөгөөд Гадаад хэргийн сайд

Л.Эрдэнэчулуун Тонга Улсын ван Тауфа-Ахоу-Тупоу Үү-д бараалхаж Монгол Улс, Тонгагийн Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоох, худалдаа, соёл жуулчлалын салбарт хэлхээ, холбоо хөгжүүлэх боломжийн талаар санал солилцов.

11.25

Гадаад хэргийн дэд сайд С.Батболд тэргүүтэй төлөөлөгчид Арабын Бүгд Найрамдах Египет Улсад ажлын айлчлал хийв. Дэд сайд Египетийн Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч бөгөөд Хөдөө аж ахуй, газрын шинэчлэлийн яамны сайд Др. Юсеф Вали, Гадаад хэргийн яамны Азийн орнуудтай харилцах асуудал эрхэлсэн дэд сайд Наги эль-Гатрифитэй хоёр орны харилцаа, олон улсын зарим асуудлаар санал солилцож, хэлэлцээ хийв.

12.01

АНУ-ын Батлан хамгаалахын бодлого хариуцсан орлогч сайд Уолтер Б.Слокомб манай улсад ирж Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, дэд сайд С.Тогоо болон албаны бусад хүмүүстэй уулзав.

12.19

Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны Ү хуралдаан болов. УИХ-ын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайд бөгөөд Монгол Улс, Европын Холбооны “Тасис” хөтөлбөрийн үндэсний зохицуулагч Ч.Улаан, Европын комиссын гадаад харилцааны Кавказ, дундад Азийн орнууд, Монголын хэлтсийн дарга ноён Кейс Витгербууд нар хоёр талын төлөөлөгчдийг тэргүүлэн оролцов.

12.19

УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Катерин С.Хантерийг хүлээн авч уулзав.

12-р сард

Дэлхийн Банкны 24 гүйцэтгэх захирлын нэг ноён Нил Хэйдэл манай улсад ирж, төр засгийн удирдлагуудтай уулзав.